

ТҮРЭГ МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭСЭГ БҮХЛИЙН УТГАТАЙ  
ЗҮЙРЛЭЛИЙН НЭГ ЖИШЭЭ

М.Ууганбаяр\*

Танихуйн утга судлалын чухал онцлог бол зүйрлэлийг сэтгэлгээ болоод хэлэнд чухал үүрэгтэй хэмээн үзэхээр илэрдэг. Метафор туршлагын нэг хүрээг өөр бусад хүрээний үүднээс ойлгох боломжийг бий болгоно. Лакофф нар зүйрлэлийг/*metaphor*/ хүний сэтгэлгээний үндсэн үзэгдэц гэж авч ярьдаг бөгөөд, зүйрлэл нь нийгмийн бодит байдлыг үүсгэдэг түүнчлэн хүний ойлголтын тогтолцоо зүйрлэлийн шинжтэй, хүний хэрхэн сэтгэх, хүртэх, мэдрэх, үйлдэхийг зүйрлэлийн ойлголтжуулалт тодорхойлдог гэж үздэг билээ. /*Lakoff and Turner 1989: 135*/ Нийгэмд төлөвшиж, харилцан үйлдэх хүний нийтлэг туршлага нь ойлгохуй хийгээд хэлийг боломжтой болгодог үндсэн хам мэдлэгийн бүтцүүдийг өдөөж өгдөг ба эдгээр хам мэдлэгийн бүтцүүд хэлний өмнөх дүрийн бүдүүвчийг агуулах бөгөөд энэ дүрийн бүдүүвчүүд зүйрлэл төлөөллийн үйл явцаар илүү хийсвэр танихуйн загварыг үүсгэдэг. Тухайн соёлын үндсэн үнэлэмж нь тэрхүү соёлын үндсэн ойлголтууд зүйрлэлийн бүтэцтэйгээ таарч байх явдал бөгөөд танихуйн хэл шинжлэлд зүйрлэл бол ярих ур маяг төдийгүй сэтгэхүйн үйл явц болдог билээ. Ерөөс зүйрлэл гэдэг нь ойлголтын нөлөөний хүрээний харилцан нөлөөлөл болж байдаг. Зүйрлэл хүний сэтгэхүйд оршиж байдаг тул хүний хэлний үйлдлэгт ихээхэн нөлөөлөх аж. Свитсэр сэтгэхүй бол бие юм гэсэн зүйрлэл буюу биеийн үүднээс оюун ухааныг харах зүйрлэлийн үзлийг Энэтхэг Европ хэлний мэдрэх хүртэхүйн үйл үгийн утга биеийн хүрээнээс оюун ухааны хүрээ рүү өргөн бөгөөд тогтвортойгоор шилжсэнийг судалсан бөгөөд англи хэлэнд “*see*” гэх үйл үг нүдээрээ хүртэх гэсэн биет утгаас гадна, “*I see what you mean*” “*Чамайг юу гэж хэлэх гэж буйг би ойлгож байна*” хэмээх өгүүлбэрт гарч буй шигээр ойлгох гэсэн зүйрлэлээр өргөжсөн утгатай байна.

Жишээ нь:

Энэтхэг Европ хэлний язгуур \*weid- “*харах*”

Герег хэлний eidon “*харах*” төгс болц oidoa “*мэдэх*” Англи хэлний *idea* “*санаа үзэл*”

Англи хэлний wise wit “*ухаантай*”

Латин хэлний video “*үзэх*”

Ирланд хэлний fios “*мэдлэг*”

Энэтхэг Европ хэлний язгуур \*k'leus “*сонсох дуулах чагнах*”

Англи хэлний listen “*сонсох, дуулах*”

Дани хэлний lystre “*дагах, дагалдах*”

Энэтхэг Европ хэлний язгуур \*geus “*амт*”

Герег хэлний geuomai “*амт*”

\* МУИС-ийн МХСС-ийн багш, доктор

Латин хэлний gustare “амт”

Гот хэлний kiusan “оролдох чармайх”

Эртний англи хэлний ceosan “сонгох”

Самгарди хэлний jus- “дуртай байх таашаах” гэх мэт.

Эндээс харахад түүхэн утгын өөрчлөл сэтгэхүй бие юм гэсэн зүйрлэлийн нөлөөгөөр бий болжээ./Sweetser 1990: 32ff/

Дүрийн бүдүүвч /image schemas/ буюу зүйрлэлийн суурь болж бие махбодын туршлага хийгээд хэл мэтийн дээд танихуйн хүрээг холбох танихуйн бүтцийн /cognitive structure/ нэг хэлбэр нь өгүүлэхүүнжилт /predication/ зураглахуйн /profile/ талаас гарч ирэх дүрслэмжийн нэг жишээ болгон хэсэг бүхлийн бүдүүвчийг түрэг хэлний жишээгээр авч үзсэн Д. Зэйрэк “Хэсэг бүхлийн бүдүүвч зүйрлэх аргаар baş толгой болон ayak “хөл” хэмээх үгийг багтаасан олон үг, хэлцийг үүсгэдэг гэж болно. Түрэг хэлний başbakan “ерөнхий сайд” başkomutan “ерөнхий захирагч” başöğretmen “ахлах багш” başkent “нийслэл” başa baş “тааралдах учрах” başını ezmek “хөдлөхгүй болгон нам дарах” гэх зэрэг үг хэлцээс биеийн хамгийн дээд хэсэг болох толгойг түрэг соёлд /бусад соёлд ч байх ихээхэн магадтай/ чухал, үнэтэй, үнэлэмжтэй, хүндтэй гэж ойлгож байгаа нь харагдаж байна. Гэтэл үүний эсрэгээр биеийн доод хэсэгт байрших хөлийг хэрэглэх. Ayak işleri ayak takımı “доод зиндааны хүмүүс” аyağının altına almak “хэмх нүдэн зодох, дордчлох” аyağının altına örtmek “хөлийг нь үнстэл долигонон дорд орох” тэргүүтэн нэрийн холбоо үг хэлцээс хөлийг толгойгоос бага үнэлэмжтэй хэмээн үздэг нь харагдаж байна. Эдгээр хэлцээс аyağının altına almak “хэмх нүдэн зодох, дордчлох” аyağının altına örtmek “хөлийг нь үнстэл долигонон дорд орох” гэх жишээ яригчийн толгой бусдын толгой дүгээ адил төвшинд тэр бүү хэл хөлнөөс доош буусан өөрөөр хэлбэл хүний биеийн хамгийн чухал үнэт хэсэг өөр хэн нэгний биеийн хамгийн үнэ хүндгүй хэсгийн доор орсныг хэлж байна. Ийнхүү эдгээр үг хүн өөрийнхөө үнэ хүндийг мэдсээр байж унагаж буй гэсэн утгыг дүрслэлийн аргаар илгэтэж байна” хэмээн бичжээ. /Zeyrek 1998: 212/

Иймэрхүү баримтыг түрэг хэлцээс гаргаж болно

Başını vermek /Aksoy : 575/

“Толгойгоо өгөх”

Сурвалж хүрээ - толгой

Зорилго хүрээ - зорилгынхоо төлөө алуулах

Başını bağlamak /Aksoy : 573/

“Гэрлүүлэх”

Сурвалж хүрээ - толгой

Зорилго хүрээ - гэрлэлт

Baş köşe /Aksoy : 577/

“Толгой булан”

Сурвалж хүрээ - толгой

Зорилго хүрээ - хүндтэй газар

Ayaklar baş başlar ayak olmak /Aksoy : 551/

“Хөл толгой толгой хөл болох”

Сурвалж хүрээ - толгой

Зорилго хүрээ - үнэ хүндтэй хүн

Сурвалж хүрээ - хөл

Зорилго хүрээ - үнэ хүндгүй хүн

Ауак съгътек /*Aksoy* : 552/  
 “Хөл чирэх”  
 Сурвалж хүрээ - хөл  
 Зорилго хүрээ - Үхэх явах  
 Толгойтой бол тос олдог  
 Тархитай бол тараг олдог /*Дашидорж, Ринчэнсамбуу: 2008 276/*  
 Сурвалж хүрээ - толгой тархи  
 Зорилго хүрээ - тос тараг  
 Толгойдоо боддог  
 Дотооддоон хадгалдаг /*Дашидорж, Ринчэнсамбуу 2008: 276/*  
 Сурвалж хүрээ - толгой  
 Зорилго хүрээ - бодох  
 Толгой ноёны  
 Тохош миний /*Дашидорж, Ринчэнсамбуу 2008: 276/*  
 Сурвалж хүрээ - толгой  
 Зорилго хүрээ - ноён  
 Хөл нь шороонд  
 Санаа нь сансарт /*Дашидорж, Ринчэнсамбуу 2008: 370/*  
 Сурвалж хүрээ - хөл  
 Зорилго хүрээ - шороо  
 Хөлдөөн сөгдүүлж  
 Хүйсэндээн мөргүүлэх /*Дашидорж, Ринчэнсамбуу 2008: 371/*  
 Сурвалж хүрээ - хөл  
 Зорилго хүрээ - сөгдөх бууж өгөх дийлдэх

Дээр бидний гарган үзүүлсэн түрэг монгол хэлний баримтыг танихуйн хэл шинжлэлийн зүйрлэл бүдүүвчийн үүднээс авч тайлах юм бол толгой хөлтэй холбоо бүхий дүр, төсөөлөл, ойлголт, үнэлэмжийг оюун ухаан бол бие махбод юм сэтгэн бодох нь биеийн үүрэг, санаа бодол тусгаар орших ахуй юм /*mind as body*/гэсэн хам мэдлэгийн зураглалыг /*mapping of concepts*/түрэг монгол хэл, соёлд илрүүлэх боломжтой нь энэ хоёр хэлнээ толгой тархи нь биеийн дээд хэсгийн хувьд сурвалжийн хүрээ болж зорилгын хүрээний талаас ерөнхий сайд, ерөнхий захирагч, ахлах багш, нийслэл, тааралдах учрах хөдлөхгүй болгон нам дарах, үнэ хүндтэй хүн, гэрлүүлэх, хүндтэй газар, зорилго үзэл санаа, хүний оюун ухаан, хоол хүнс, бодох, сэтгэх, ноён эзэн гэсэн утгыг илтгэж байгаа бол хөл нь биеийн доод хэсгийн хувьд сурвалжийн хүрээ болж зорилгын хүрээний талаас доод зиндааны хүмүүс, хэмх нүдэн зодох, дордчлох, үхэх, хөлийг нь үнстэл долигонон дорд орох, шороо, бууж өгөх, дийлдэх гэсэн утгыг илэрхийлж байгаагаар нотлогдож байна.

## НОМ ЗҮЙ

- Дашдорж Ж. Ринчинсамбуу Г. (2008) *Монгол ардын зүйр цэцэн үг*, Улаанбаатар.,  
Aksoy Cımer Asim (1991) *Atasözleri ve Deyimler Sözlüğü 1 Atasözleri Sözlüğü*, Istanbul.,  
Aksoy Cımer Asim (1991) *Atasözleri ve Deyimler Sözlüğü 2 Deyimler Sözlüğü*, Istanbul.,  
Johnson Mark. (1987) *The Body in the Mind: the Bodily Basis of Reason and Imagination*  
Chicago: University of Chicago Press.,  
Lakoff George and Mark Johnson (1980) *Metaphors We Live By*, Chicago: University of  
Chicago Press  
Lakoff George and Mark Turner. (1989) *More than Cool Reason: a field guide to Poetic  
Metaphor*, Chicago: University of Chicago Press.,  
Sweetser Eve E. (1990) *From Etymology to Pragmatics* Cambridge: Cambridge University  
Press.,  
Zeyrek Deniz (1998) *Bilişsel Dilbilim Dil Ulamları ve Türkçe Eylemlerin Kavramsal Yapısı ile  
İlgili Gözlemler Doğan Aksan Armağanı*, Ankara.,

## SUMMARY

In this article, the author discusses some facts of whole part image schema in the Turkish and Mongolian languages.

In Turkish and Mongolian, the phrases which contain the word 'baş', 'tolgoi' or 'head' express the meaning of leader or ability, whereas the phrases connecting to the word 'ayak', 'hol' or 'feet' express the meaning of disability or ugly.